



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024. 01. 30 № 05

Солонго 1, 2 хорооллын төслийн  
талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2/-т заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээсэн боловч 1,400,000 (нэг сая дөрвөн зуу) гаруй иргэнтэй Улаанбаатар хот агаарын бохирдлоороо дэлхийд тэргүүлж, иргэд “үхлийн хөндийд” амьдарсаар байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд өнгөрсөн 2008-2016 онд улсын төсвөөс 164,100,000,000 (нэг зуун жаран дөрвөн тэрбум нэг зуун сая) төгрөг, 104,700,000 (нэг зуун дөрвөн сая долоон зуун мянга) ам.долларын зээл, 48,600,000 (дөчин найман сая зургаан зуун мянга) ам.долларын буцалтгүй тусламж, 2017-2020 онд 456,100,000,000 (дөрвөн зуун тавин зургаан тэрбум нэг зуун сая) төгрөг, 2020-2023 онд 100,000,000,000 (нэг зуун тэрбум) орчим төгрөгийг зарцуулсан ч үр дүнд хүрсэнгүй. Улмаар агаарын бохирдлоос улбаатай өвчлөл, нас баралт жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Агаарын бохирдлыг бууруулах шийдлүүдийн нэг нь гэр хорооллын янданг цөөлж, орон сууцжуулах төрийн оновчтой бодлого бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх бодлого, чиглэлийн нэг болох Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах зорилт бүхий Солонго-1, Солонго-2 хорооллын төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн агентлаг болох Экспорт-Импорт банк /ЭКСИМ/-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр болсон.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1. Солонго-1, Солонго-2 хорооллын төслийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчээр шалгарсан гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн талаар;
2. Тус төсөл нь ашиглалтад орсноор түрээслэх болон худалдах үнэ нь зорилт бүхий иргэдийн худалдан авах чадварт нийцэж чадах эсэх талаар;

2024000011




3. Төслийн барилга угсралтын ажилтай холбоотой төрөөс олгох зөвшөөрлүүд болон тулгамдаж байгаа асуудлуудын талаар болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН



Н.ГАНИБАЛ

2024000011